

**МОНГОЛ УЛС ДАХЬ ШУДАРГА ЁСНЫ ХҮРТЭЭМЖ ТӨСЛИЙН БҮЛГИЙН СУДАЛГААНЫ
НЭГТГЭСЭН ТАЙЛАН
COMMUNITY REPORTS SUMMARY – EJAM / A2J WG**

Агуулга

ХУРААНГУЙ	3
УДИРТГАЛ	4
НЭГ. ШУДАРГА ЁСНЫ ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААР	5
1.1. Хүн төвт үйлчилгээг бий болгох, түүнийг хүргэх	5
1.2. Засаглалын дэмжлэг ба дэд бүтэц.....	6
1.3. Хүмүүсийг чадавхжуулах	6
ХОЁР. БҮЛГИЙН СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО, СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ	7
2.1. Судалгааны зорилго ба шүүх эрх мэдлийн шинэтгэлтэй уялдах байдал.....	7
2.2. Судалгааны үр дүн ба шүүхийн хараат бус байдал	7
2.3. Олон нийтийн итгэл ба шүүх эрх мэдлийн легитим шинж	8
ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	9
3.1. Судалгаанд хамрагдсан нийгмийн бүлгүүдэд нийтлэг давтагдсан асуудлуудын шинжилгээ	9
3.2. Судалгаанд оролцогчдоос санал болгож буй шийдлийн тойм.....	11
3.3. Зөвлөмж, санал	11
ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ИРГЭДИЙН ТОДОРХОЙЛСОН ШУДАРГА ЁСНЫ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ (ДЭЛГЭРЭНГҮЙ ХҮСНЭГТ БАЙДЛААР)	15

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1. Нийтлэг байдлаар шударга ёсны хүртээмжийн саадыг тодорхойлсон байдал.....	9
Хүснэгт 2. Бүтцийн шинжтэй бэрхшээл: Тухайн бүс нутагт шүүх байхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай хүний хэрэгцээ шаардлагад нийцээгүй барилга байгууламж гэх мэт	15
Хүснэгт 3. Хууль зүйн болон процессын шинжтэй бэрхшээл: Хууль, эрх зүйн зохицуулалт нь бэрхшээл үүсгэдэг, бичиг баримт бүрдүүлэхэд төвөгтэй, ойлгомжгүй байдал гэх мэт	16
Хүснэгт 4. Санхүүгийн шинжтэй бэрхшээл: Шүүхийн хураамж, зорчих зардал, хууль зүйн үйлчилгээний зардал гэх мэт	18
Хүснэгт 5. Нийгмийн болон соёлын шинжтэй бэрхшээл: Нийгмийн гадуурхалт, үл тоох, хэлний бэрхшээл, итгэлцлийн дутагдал гэх мэт	19
Хүснэгт 6. Захиргааны шинжтэй бэрхшээл: Үйл ажиллагааны удаашрал, тодорхой бус байдал гэх мэт.....	21
Хүснэгт 7. Мэдээллийн хүртээмжтэй холбоотой бэрхшээл: Хууль, эрх зүйн мэдээлэл, боловсролын хүртээмж гэх мэт	22
Хүснэгт 8. Технологи, цахимжилт дагасан бэрхшээл: Шүүх хурал цахимаар явагдах, шүүхийн процессын талаарх мэдээллийг шүүгчийн туслахаас viber-аар авах, хууль, эрх зүйн баримт бичгүүдэд цахимаар санал авах гм. “цахим” үйл ажиллагаанууд нь нийгмийн тодорхой бүлгүүдийн хувьд хэр байдаг вэ? (зөвхөн энэ жишээгээр хязгаарлагдахгүй)	23
Хүснэгт 9. Судалгааг гүйцэтгэсэн Төрийн бус байгууллагуудын товч танилцуулга	25
Хүснэгт 10. Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдыг нийгмийн бүлгийн үзүүлэлт	27
Хүснэгт 11. Судалгаанд оролцогчдын нарийвчилсан мэдээлэл	27

ХУРААНГУЙ

Энэхүү судалгаа нь “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” (EJAM) төслийн хүрээнд байгуулагдсан Шударга ёсны хүртээмжийн ажлын хэсэг (A2J WG)-ийн санаачилгаар Монгол Улсад шударга ёсны хүртээмжид тулгарч буй бодит саад, бэрхшээлийг тодорхойлох зорилгоор хэрэгжүүлсэн нэгдсэн бүлгийн судалгаа юм. Судалгааг иргэний нийгмийн 8 байгууллага хамтран гүйцэтгэж, ахмад настан, хөдөө орон нутгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон иргэд зэрэг нийгмийн бүлгийн нийт 374 оролцогчийг хамруулсан болно.

Судалгааны хүрээнд шударга ёсны хүртээмжид нөлөөлж буй (1)бүтцийн, (2)хууль зүйн болон процессын, (3)санхүүгийн, (4) хандлага болон соёлын, (5)захиргааны, (6)мэдээллийн, (7) технологи, цахимжилттай холбоотой гэсэн нийт 7 төрлийн бэрхшээлийг тодорхойлж, иргэдийн бодит туршлага, үнэлэмжид тулгуурлан дүн шинжилгээ хийсэн.

Судалгааны үр дүнгээс харахад шүүхийн байгууллагын газарзүйн төвлөрөл, хүртээмжгүй барилга байгууламж, тусгай хэрэгцээтэй бүлгүүдэд нийцээгүй орчин нь иргэдийн шүүхэд хандах бодит боломжийг хязгаарлаж байна. Үүний зэрэгцээ хууль зүйн процессын ойлгомжгүй байдал, бичиг баримт бүрдүүлэх шат дамжлага их, мэдээлэл, тайлбар дутмаг байдал нь иргэдийг эрхээ эдлэхээс татгалзах, эсхүл процессын явцад төөрөгдөх нөхцөлийг бүрдүүлж байгааг оролцогчид онцолсон.

Санхүүгийн хувьд шүүхийн хураамж, зорчих зардал, хууль зүйн үйлчилгээний төлбөр, хэлмэрч, орчуулагчийн зардал нь ялангуяа ахмад настан, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүчирхийллийн хохирогчдын хувьд шударга ёсны хүртээмжид ноцтой саад болж байгааг судалгаа харуулж байна. Мөн нийгмийн болон соёлын түвшинд төрийн байгууллагын ажилтнуудын хандлага, хохирогчийг буруутгах өнгө аяс, хэлний болон ойлголтын бэрхшээл, шүүхэд итгэх итгэл сул байгаа нь шударга ёсны тогтолцоонд иргэдийн оролцоог улам бүр бууруулж байна.

Судалгаанд оролцогчид дээрх бэрхшээлүүдийг даван туулахын тулд хүн төвт шударга ёсны үйлчилгээний загвар нэвтрүүлэх, хууль зүйн болон процессын зохицуулалтыг хялбаршуулах, санхүүгийн дэмжлэг, үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааг өргөжүүлэх, мэдээллийн ил тод, ойлгомжтой байдлыг хангах, хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх, мөн технологи, цахим шийдлийг хүртээмжтэй, ялгаваргүй байдлаар нэвтрүүлэх шаардлагатай талаар бодитой санал дэвшүүлсэн болно.

УДИРТГАЛ

Шударга ёсны хүртээмж нь хүний эрхийг бодитойгоор эдлэх, хууль дээдлэх ёсыг төлөвшүүлэх, ардчилсан засаглалыг бэхжүүлэх үндсэн нөхцөл болдог. Иргэн бүр хууль, эрх зүйн тогтолцоог ойлгох, ашиглах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд шударга, үр нөлөөтэй хамгаалалт авах боломжтой байх нь нийгмийн шударга байдал, иргэдийн төрд итгэх итгэлийн суурь юм. Гэвч бодит амьдрал дээр хууль, шүүхийн тогтолцоо бүх хүнд ижил тэгш хүртээмжтэй хүрч чаддаггүй, ялангуяа нийгмийн эмзэг болон олон талт хэрэгцээтэй бүлгүүдийн хувьд олон төрлийн саад, бэрхшээл тулгарсаар байна.

Олон улсын судалгаа, бодлогын баримт бичгүүдэд дурдсанаар шударга ёсны хүртээмжийг хязгаарлаж буй саад нь зөвхөн хууль, эрх зүйн зохицуулалтаас хамаарахгүй бөгөөд шүүхийн бүтэц, байршил, дэд бүтэц, санхүүгийн боломж, мэдээллийн хүртээмж, нийгмийн хандлага, соёлын хэвшмэл ойлголт, технологийн шийдлүүдийн хүртээмж зэрэг олон хүчин зүйлээс шалтгаалдаг цогц асуудал юм. Иймээс шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого, шийдэл нь хүн төвт, нотолгоонд суурилсан, олон талын оролцоотой байх шаардлагатайг олон улсын сайн түршлага харуулж байна

Энэхүү судалгаа нь “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” (EJAM) төслийн хүрээнд байгуулагдсан Шударга ёсны хүртээмжийн ажлын хэсэг (A2J WG)-ийн санаачилгаар Монгол Улсад шударга ёсны хүртээмжид тулгарч буй бодит саад, бэрхшээлийг иргэдийн амьдрал дээрх түршлага, үнэлэмжид тулгуурлан тодорхойлох зорилгоор хэрэгжүүлсэн нэгдсэн бүлгийн судалгаа юм. Судалгааг иргэний нийгмийн байгууллагууд хамтран гүйцэтгэж, ахмад настан, хөдөө орон нутгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд болон гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон иргэд зэрэг нийгмийн олон талт бүлгийг хамруулсан нь уг судалгааны онцлог юм

Судалгааны гол зорилго нь Монгол Улсад шударга ёсны хүртээмжид нөлөөлж буй бүтцийн, хууль зүйн болон процессын, санхүүгийн, нийгмийн болон соёлын, захиргааны, мэдээллийн, хандлагын, технологи, цахимжилттай холбоотой саад, бэрхшээлийг тодорхойлон гаргаж, тэдгээрийн иргэдийн эрхээ хэрэгжүүлэхэд үзүүлж буй бодит нөлөөллийг илрүүлэхэд оршино. Үүний зэрэгцээ оролцогчдын дэвшүүлсэн санал, шийдэлд тулгуурлан шударга ёсны тогтолцоог илүү хүртээмжтэй, хүн төвт байдлаар сайжруулахад чиглэсэн бодлогын хэлэлцүүлэг, шийдвэр гаргалтад хувь нэмэр оруулах зорилготой.

Энэхүү нэгдсэн тайланд тус судалгааны арга зүй, хамрах хүрээ, оролцогчдын бүтэц, судалгааны үр дүнг нэгтгэн дүгнэж, шударга ёсны хүртээмжийг сайжруулахад анхаарах шаардлагатай гол асуудлууд, чиг хандлага, боломжит шийдлүүдийг тодорхойлон тусгасан болно. Тайлан нь бодлого боловсруулагчид, хууль тогтоогчид, шүүхийн байгууллагууд, иргэний нийгмийн байгууллагууд болон хүний эрхийн чиглэлээр ажиллаж буй бусад оролцогч талуудад бодит мэдээлэл, нотолгоонд суурилсан дэмжлэг болох зорилготой юм.

НЭГ. ШУДАРГА ЁСНЫ ХҮРТЭЭМЖИЙН ТАЛААР

Шударга ёсны хүртээмж нь иргэн бүр хууль, эрх зүйн тогтолцоог ойлгох, ашиглах, эрх нь зөрчигдсөн тохиолдолд үр нөлөөтэй, цаг хугацаанд нь, тэгш оролцоотойгоор хамгаалалт авах бодит боломжтой байхыг илэрхийлдэг цогц ойлголт юм. Энэхүү ойлголт нь зөвхөн шүүхэд хандах эрхээр хязгаарлагдахгүй бөгөөд маргаан, зөрчлийг шударгаар шийдвэрлүүлэх, хууль зүйн мэдээлэл, зөвлөгөө авах, шийдвэрийн хэрэгжилтийг хангах зэрэг бүх үе шатыг хамарна.

Олон улсын судалгаа, бодлогын баримт бичгүүдэд шударга ёсны хүртээмжийг хүний эрхийн бодит хэрэгжилт, ардчиллын чанар, нийгмийн итгэлцлийн үндсэн шалгуур гэж үздэг. Гэсэн хэдий ч бодит байдал дээр шүүх, хууль зүйн тогтолцооны бүтэц, процесс, санхүү, мэдээлэл, хандлага, технологийн хүчин зүйлсээс шалтгаалан иргэд, ялангуяа нийгмийн эмзэг бүлгүүд шударга ёсны үйлчилгээнд тэгш хүртээмжтэй хамрагдаж чаддаггүй хэвээр байна. Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага (ЭЗХАХБ)-аас дэвшүүлсэн хүн төвт шударга ёсны тогтолцоо нь энэхүү асуудлыг шийдвэрлэх суурь үзэл баримтлал бөгөөд доорх үндсэн чиглэлүүдэд тулгуурладаг.

1.1. Хүн төвт үйлчилгээг бий болгох, түүнийг хүргэх

Хүн төвт шударга ёсны үйлчилгээ гэдэг нь хууль, шүүхийн тогтолцоог байгууллагын дотоод логик, хуульчдын мэргэжлийн өнцгөөс бус, харин иргэдийн бодит хэрэгцээ, амьдралын нөхцөл байдал, нийгмийн онцлогт нийцүүлэн төлөвлөж, хэрэгжүүлэхийг хэлнэ. Энэ хүрээнд иргэд шударга ёсны үйлчилгээнд хандахад тулгарч буй саад, бэрхшээлийг урьдчилан тодорхойлж, тэдгээрийг арилгах шийдлийг үйлчилгээнд тусгах шаардлагатай.

Нийгмийн тодорхой бүлгүүд, тухайлбал ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, хөдөө орон нутгийн иргэд, хэлний цөөнх бүлгүүдийн хувьд шударга ёсны үйлчилгээ авахад байршлын алслагдал, хүртээмжгүй орчин, ойлгомжгүй процесс, мэдээллийн хомсдол зэрэг онцгой бэрхшээлүүд үүсдэг. Иймээс шүүхийн байр, үйл ажиллагааны зохион байгуулалт, процессын шийдлүүд нь эдгээр бүлгийн онцлог хэрэгцээнд нийцсэн байх, ялгаварлалгүй, аюулгүй, сэтгэл зүйд ээлтэй орчныг бүрдүүлэхэд чиглэгдэх ёстой.

Хүн төвт үйлчилгээ нь зөвхөн шүүхийн шатанд бус, маргаан үүсэхээс өмнөх урьдчилан сэргийлэх, мэдээлэл өгөх, зөвлөгөө үзүүлэх, шүүхийн дараах шийдвэрийн хэрэгжилтийг дэмжих зэрэг бүхий л үе шатанд хэрэгжих нь шударга ёсны хүртээмжийг бодитоор нэмэгдүүлэх чухал нөхцөл болдог.

Сайн жишиг

Хүн төвт үйлчилгээг бий болгох, түүнийг хүргэхэд Хууль зүйн хэрэгцээний судалгаа чухал үүрэгтэй бөгөөд сүүлийн жилүүдэд энэ төрлийн судалгааны тоо нэмэгдэж байна. Нээлттэй нийгэм сангаас 2019 онд хэвлэгдсэн Хууль зүйн хэрэгцээний судалгаа ба шударга ёсны хүртээмж гэх тайлан¹д сүүлийн 25 жилийн хугацаанд 55 гаруй томоохон хэмжээний буюу 1,000 ба түүнээс дээш оролцогчдыг хамруулсан үндэсний хэмжээний хууль зүйн хэрэгцээний

¹ OECD/Open Society Foundations (2019), Legal Needs Surveys and Access to Justice, OECD Publishing, Paris, p.25. <https://doi.org/10.1787/g2g9a36c-en>

бие даасан судалгаа хийгдсэн талаар дурджээ. Тус тайланд Монгол Улсын хувьд 2016 онд Нээлттэй нийгэм форумаас нийт хүн амын төлөөлөл 1630 хүнийг биечлэн хамруулсан Хууль зүй хэрэгцээний судалгаа хийгдсэн талаар дурдсан байна.²

1.2. Засаглалын дэмжлэг ба дэд бүтэц

Шударга ёсны хүртээмжийг хангахын тулд төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоог тодорхой болгож, тэдгээрийн хоорондын уялдаа холбоог хангах шаардлагатай. Засаглалын дэмжлэг гэдэг нь зөвхөн хууль тогтоомж батлах үйл явцаар хязгаарлагдахгүй бөгөөд шүүх, хууль сахиулах байгууллага, гүйцэтгэх засаглал, парламент, орон нутгийн байгууллагуудын хамтын ажиллагаа, зохион байгуулалтын чадавхтай шууд холбоотой.

Дэд бүтцийн хувьд шүүхийн байгууллагын байршил, хүртээмжтэй барилга байгууламж, дотоод зохион байгуулалт, мэдээллийн систем нь иргэдийн шударга ёсны үйлчилгээнд хандах боломжийг бодитоор тодорхойлдог. Байршлын төвлөрөл, хуучирсан барилга, хүртээмжийн стандарт хангаагүй орчин нь ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, хөдөө орон нутгийн иргэдэд ноцтой саад болдог.

Мөн засаглалын түвшинд шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэх бодлого, арга хэмжээг төлөвлөхдөө салбар хоорондын уялдаа холбоо, санхүүжилтийн тогтвортой эх үүсвэр, нотолгоонд суурилсан шийдвэр гаргалтыг хангах нь чухал юм. Үүний үр дүнд шударга ёсны тогтолцоо нь тасралтгүй, урт хугацаанд сайжрах боломж бүрдэнэ.

1.3. Иргэнийг чадавхжуулах

Шударга ёсны хүртээмж нь зөвхөн байгууллагын зохион байгуулалтаас хамаарахгүй бөгөөд иргэд өөрсдөө эрхээ ойлгож, хэрэгжүүлэх мэдлэг, чадвартай байхтай салшгүй холбоотой. Иргэдийн эрх зүйн боловсрол сул, хууль зүйн процесс ойлгомжгүй, мэдээлэл авах суваг хязгаарлагдмал нөхцөлд шударга ёсны тогтолцоо бодитоор ажиллах боломж хязгаарлагддаг.³

Иргэдийг чадавхжуулах нь нэг талаас хууль, эрх зүйн анхан шатны мэдлэг олгох, ойлгомжтой мэдээлэл хүргэх, үнэ төлбөргүй болон хүртээмжтэй хууль зүйн туслалцааг өргөжүүлэхийг шаарддаг. Нөгөө талаас шүүх, хууль зүйн салбарт ажиллаж буй албан хаагчдыг хүний эрхэд суурилсан, эмзэг бүлгийн хэрэгцээг ойлгосон, харилцааны өндөр соёлтой байхад чиглэсэн сургалт, чадавхжуулалт зайлшгүй шаардлагатай.⁴

Иргэд болон хууль зүйн салбарын оролцогчдыг зэрэгцүүлэн чадавхжуулснаар шударга ёсны тогтолцоонд итгэх итгэл нэмэгдэж, иргэд эрхээ хэрэгжүүлэхээс зайлсхийх бус, идэвхтэй оролцох нөхцөл бүрдэх юм.

² OECD/Open Society Foundations (2019), Legal Needs Surveys and Access to Justice, OECD Publishing, Paris, p.27. <https://doi.org/10.1787/g2g9a36c-en>

³ OECD (2021), OECD Framework and Good Practice Principles for People-Centred Justice, OECD Publishing, Paris, pp.67-68. <https://doi.org/10.1787/cdc3bde7-en>.

⁴ OECD (2021), OECD Framework and Good Practice Principles for People-Centred Justice, OECD Publishing, Paris, <https://doi.org/10.1787/cdc3bde7-en>.

ХОЁР. БҮЛГИЙН СУДАЛГААГ ГҮЙЦЭТГЭСЭН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ОРОЛЦОО, СУДАЛГААНЫ АЧ ХОЛБОГДОЛ

Энэхүү судалгааг гүйцэтгэсэн төрийн бус байгууллагууд (*Хавсралт 1-ээс танилцуулга үзнэ үү*) нь хүний эрх, шударга ёсны хүртээмж, нийгмийн эмзэг бүлгийн хамгаалал, бодлого, засаглалын чиглэлээр олон жилийн туршид тасралтгүй ажиллаж ирсэн, тухайн бүлгүүдтэй шууд харилцаж, бодит туршлага хүримтлүүлсэн байгууллагууд юм. Судалгаанд оролцсон байгууллагууд нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд, хөдөө орон нутгийн иргэд, гэмт хэрэг, зөрчлийн хохирогчид зэрэг нийгмийн олон талт бүлгийн эрх, ашиг сонирхлыг төлөөлөн ажилладаг нь уг судалгааны бодитой, нотолгоонд суурилсан шинжийг хангах чухал нөхцөл болсон.

Эдгээр төрийн бус байгууллагууд нь “Тэгш эрх, шударга ёсыг хүн бүрд” (EJAM) төслийн хүрээнд байгуулагдсан Шударга ёсны хүртээмжийн ажлын хэсэг (A2J WG)-ийн бүрэлдэхүүнд ажиллах замаар шүүх эрх мэдлийн шинэтгэлийг иргэдийн бодит хэрэгцээ, амьдрал дээрх туршлагатай уялдуулах, бодлого, институцийн түвшинд хэрэгжих өөрчлөлтүүдийг доороос дээш чиглэлтэй нотолгоогоор хангах үүргийг гүйцэтгэх хүрээнд ажиллаж байгаа болно. Тухайлбал,

2.1. Судалгааны зорилго ба шүүх эрх мэдлийн шинэтгэлтэй уялдах байдал

Судалгааны үндсэн зорилго нь Монгол Улсад шүүх, хууль зүйн тогтолцооны үйл ажиллагаа иргэдэд бодитоор хэрхэн хүрч байгаа, ямар бүлгүүдэд, ямар шалтгаанаар шударга ёсны хүртээмж хязгаарлагдаж байгааг иргэдийн шүүд туршлага, үнэлэмжид тулгуурлан тодорхойлох явдал юм. Энэ нь шүүх эрх мэдлийн шинэтгэлийг зөвхөн хууль, институцийн зохион байгуулалтын түвшинд бус, иргэдийн итгэл, оролцоо, хүлээлтийн өнцгөөс үнэлэх боломжийг бүрдүүлж байна.

Шүүх эрх мэдлийн шинэтгэл нь шүүгчийн хараат бус байдал, шүүхийн дотоод засаглал, институцийн хариуцлагыг бэхжүүлэхээс гадна иргэд шүүхэд хандах боломж, шүүхийн үйл ажиллагааг ойлгох байдал, шүүхийн шийдвэрийг шударга, үндэслэлтэй гэж хүлээн зөвшөөрөх түвшинг нэмэгдүүлэх, шүүхэд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэхэд чиглэгдэх учиртай. Энэ утгаараа уг судалгаа нь шүүхийн шинэтгэлийн бодлого, арга хэмжээг хүн төвт, хүртээмжид суурилсан байдлаар хэрэгжүүлэхэд шаардлагатай нотолгооны суурийг бүрдүүлнэ үзэж байгаа болно.

2.2. Судалгааны үр дүн ба шүүхийн хараат бус байдал

Судалгааны үр дүнгээс харахад иргэдийн хувьд шүүхийн хараат бус байдлыг зөвхөн хуульд заасан баталгаагаар бус, харин процессын шударга байдал, албан хаагчдын хандлага, шийдвэр гаргах ил тод байдал, нөлөөлөл, дарамтгүй мэт харагдах байдлаар дамжуулан үнэлж байгааг харуулж байна. Иргэд шүүхийн үйл ажиллагаанд тулгарч буй ойлгомжгүй, удаашралтай, ялгавартай мэт мэдрэмж төрүүлдэг нөхцөл байдлыг шүүхийн хараат бус байдал сул байна гэж хүлээн авах хандлага ажиглагдсан болно.

Иймээс судалгаанд оролцсон төрийн бус байгууллагуудын цуглуулсан мэдээлэл нь шүүхийн хараат бус байдлыг иргэдийн хүлээн зөвшөөрөл, итгэлцлийн түвшинд хэрхэн бодитоор мэдрэгдэж байгааг илэрхийлсэн чухал үзүүлэлт болж байна. Энэ нь шүүх эрх

мэдлийн шинэтгэлийн хүрээнд хараат бус байдлын баталгааг зөвхөн хууль зүйн хүрээнд бус, практик хэрэгжилтийн түвшинд бэхжүүлэх шаардлагыг тодотгож өгч байгаа болно.

2.3. Олон нийтийн итгэл ба шүүх эрх мэдлийн легитим шинж

Шүүх эрх мэдлийн легитим шинж нь иргэд шүүхийн шийдвэрийг хууль ёсны, шударга, үндэслэлтэй гэж хүлээн зөвшөөрөх, түүнийг дагаж мөрдөхөд бэлэн байх түвшингээр илэрхийлэгддэг. Судалгааны үр дүнгээс харахад шүүхэд хандах явцад тулгарч буй санхүүгийн дарамт, мэдээллийн хомсдол, харилцааны соёлын асуудал, хохирогчийг буруутгах хандлага зэрэг нь иргэдийн шүүхэд итгэх итгэлийг сулруулж, улмаар шүүх эрх мэдлийн легитим шинжид сөргөөр нөлөөлж байна.

Энэхүү судалгааг гүйцэтгэсэн төрийн бус байгууллагууд нь олон нийтийн итгэл буурахад нөлөөлж буй эдгээр хүчин зүйлсийг системтэйгээр илрүүлж, бодлогын түвшинд авч үзэх шаардлагатай асуудлуудыг тодорхойлсноороо шүүх эрх мэдлийн шинэтгэлд чухал хувь нэмэр оруулж байна. Судалгааны дүн нь шүүхийн үйл ажиллагааг илүү ил тод, ойлгомжтой, иргэдэд ээлтэй болгох нь шүүхийн институцийн легитим байдлыг бэхжүүлэх суурь нөхцөл болох болно.

ГУРАВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮН

3.1. Судалгаанд хамрагдсан нийгмийн бүлгүүдэд нийтлэг давтагдсан асуудлын дүн шинжилгээ

Хүснэгт 1. Нийтлэг байдлаар шударга ёсны хүртээмжийн саадыг тодорхойлсон байдал

Нийгмийн бүлэг	Бүтцийн саад	Хууль зүй, процесс	Санхүү	Мэдээлэл	Хандлага / соёл	Захиргаа	Технологи
Ахмад настан	3	2	3	2	2	2	1
Хөдөө орон нутгийн иргэд	3	3	2	2	2	3	1
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	3	3	3	2	2	3	2
Хүүхэд	2	3	3	1	3	2	1
Эмэгтэйчүүд	2	3	2	1	3	2	1
Залуучууд	1	2	1	3	2	2	2

Тайлбар: ● Ногоон = бага саад (1) ● Шар = дунд саад (2) ● Улаан = өндөр саад (3)

Судалгаанд хамрагдсан ахмад настан, хөдөө орон нутгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, хүүхэд, залуучууд, эмэгтэйчүүд болон гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон иргэдийн түршлага, үнэлгээнд тулгуурлан үзэхэд шударга ёсны хүртээмжид сөргөөр нөлөөлж буй олон давтагдсан, тогтолцооны шинжтэй дараах нийтлэг асуудлууд илэрч байна. Үүнд:

1.Шүүхэд хандах бодит боломж хязгаарлагдмал байдал: Судалгаанд оролцсон бүх бүлгийн хувьд шүүхийн байгууллагын байршлын төвлөрөл, алслагдсан зай, хүртээмжгүй барилга байгууламж нь шүүхэд хандах бодит боломжийг хязгаарлаж буй нийтлэг асуудал байв. Ялангуяа хөдөө орон нутгийн иргэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд зам, тээврийн хүндрэл, олон удаагийн зорчих шаардлага нь шүүхэд хандах шийдвэр гаргахад шууд нөлөөлж, зарим тохиолдолд эрхээ хамгаалахаас бүрэн татгалзахад хүргэж байна.

Энэ нь шударга ёсны хүртээмж нь хууль зүйн эрх зүйн түвшинд баталгаажсан боловч дэд бүтцийн түвшинд бодитоор хангагдаагүй байгааг харуулж байна.

2.Хууль зүйн процессын ойлгомжгүй, төвөгтэй байдал: Бүх бүлгийн оролцогчид хууль зүйн процессыг ойлгомжгүй, хэт төвөгтэй, шат дамжлага ихтэй гэж үнэлсэн нь нийтлэг давтагдсан асуудал байв. Бичиг баримт бүрдүүлэх шаардлага, нотлох баримтын стандарт, процессын дарааллыг иргэд өөрсдөө ойлгож, дагаж мөрдөхөд хүндрэлтэй байгаа нь шүүхийн өмнөх тэгш байдлыг бодитоор алдагдуулж байна.

Ялангуяа хүүхэд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд процессын тайлбар дутмаг, хууль зүйн хэллэг хэт мэргэжлийн байгаагаас шүүхийн явцад төөрөгдөх, эрхээ бүрэн хэрэгжүүлж чадахгүй байх эрсдэл өндөр байна.

3.Санхүүгийн дарамт нь шүүхэд хандах шийдвэрт шууд нөлөөлж буй байдал: Шүүхийн хураамж, зорчих зардал, өмгөөлөгчийн хөлс, шинжилгээ, нотариатын зардал зэрэг нь судалгаанд хамрагдсан бүх бүлгийн хувьд шүүхэд хандахад саад болж буй бодит шалтгаан гэж дурдагдсан. Олон оролцогч “эрх нь зөрчигдсөн ч шүүхэд хандахад санхүүгийн боломж хүрэхгүй” гэж илэрхийлсэн нь шударга ёсны хүртээмж эдийн засгийн хүчин зүйлээс шууд хамааралтай байгааг харуулж байна.

Энэ нь үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааны тогтолцоо бодитоор хүрэлцэхгүй, эсхүл жигд бус хэрэгжиж байгааг илтгэж байна.

4.Албан хаагчдын хандлага, харилцааны соёлын асуудал: Судалгаанд хамрагдсан бараг бүх бүлгийн оролцогчид шүүх, хууль сахиулах байгууллагын зарим албан хаагчдын хүйтэн, үл тоосон, захирангүй, буруутгасан өнгө аяс бүхий хандлага нь шүүхэд итгэх итгэлийг сулруулж байгааг онцолсон. Ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд, гэмт хэрэг, зөрчлийн хохирогчдын хувьд буруутгах хандлага, мэдрэмжгүй харилцаа нь хоёрдогч хохирол үүсгэж байгааг судалгаа тодорхой харуулж байна.

Энэхүү асуудал нь шүүхийн хараат бус байдал, шударга байдлыг иргэд процессын мэдрэмжээр дамжуулан үнэлж байгааг илтгэж байна.

5.Мэдээллийн хүртээмж, тайлбар дэмжлэг дутмаг байдал: Бүх бүлгийн хувьд шүүхийн процессын талаар ойлгомжтой, цаг тухайд нь, хүртээмжтэй мэдээлэл авах боломж хязгаарлагдмал байгааг онцолсон. Шүүхийн шийдвэр, дараагийн алхам, эрх, үүргийн талаарх тайлбар хангалтгүйгээс иргэд шүүхийн дараах шатанд (шийдвэр гүйцэтгэл, давж заалдах гэх мэт) эрхээ хэрэгжүүлж чадахгүй үлдэх тохиолдол нийтлэг байна.

Цахимжилт нэмэгдэж байгаа хэдий ч ахмад настан, хөдөө орон нутгийн иргэд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хувьд цахим мэдээлэл бодитоор хүртээмжтэй бус хэвээр байна.

6.Шүүхэд итгэх итгэл сул, легитим байдлын асуудал: Дээр дурдсан нийтлэг бэрхшээлүүдийн нийлбэр нөлөөллөөр шүүхэд итгэх итгэл сул, шүүхийн шийдвэрийг шударга, бодитой гэж хүлээн зөвшөөрөх байдал буурч байгааг судалгааны бүх бүлэгт ажиглаж байна. Иргэдийн хувьд шударга ёс нь зөвхөн эцсийн шийдвэрээр бус, харин процессын явц, хандлага, хүртээмжээр хэмжигдэж байгаа нь судалгааны гол дүгнэлт юм.

Судалгаанд хамрагдсан нийгмийн бүлгүүдэд давтагдан илэрч буй эдгээр асуудлууд нь шударга ёсны хүртээмжийг салангид асуудал бус, харин харилцан уялдаа бүхий системийн доголдол болохыг харуулж байна. Иймээс эдгээр асуудлыг шийдвэрлэх бодлого, шинэтгэл нь нэг удаагийн зохицуулалтаар хязгаарлагдах бус, хүн төвт, хүртээмжид суурилсан, институцийн түвшний цогц өөрчлөлт байх шаардлагатай юм.

3.2.Судалгаанд оролцогчдоос санал болгож буй шийдлийн тойм

Энэхүү нэгдсэн судалгааны үр дүнгээс харахад Монгол Улсад шударга ёсны хүртээмж нь хууль, шүүхийн тогтолцооны формаль оршин тогтнолоор бус, харин иргэдийн бодит хэрэгцээ, нөхцөл байдалд нийцсэн үйлчилгээ, орчин, хандлагаар тодорхойлогдож байна. Одоогийн тогтолцоо нь нийгмийн эмзэг бүлгүүдийн хувьд олон шат дамжлагатай, зардал өндөр, ойлгомжгүй, сэтгэлзүйн дарамт ихтэй хэвээр байгаа нь шударга ёсны хүртээмжийг бодитоор хязгаарлаж байна.

Судалгаа нь шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэхэд хүн төвт хандлага зайлшгүй шаардлагатайг тодорхой харууллаа. Үүнд шүүхийн дэд бүтэц, процесс, мэдээлэл, үйлчилгээ нь иргэдийн нас, хүйс, хөгжлийн онцлог, газарзүйн байршил, нийгмийн нөхцөлд нийцсэн байх, мөн төрийн байгууллагын ажилтнуудын ёс зүй, харилцаа, хариуцлагыг бодитой сайжруулах шаардлага нэн тэргүүнд тавигдаж байна.

Түүнчлэн шүүхийн шийдвэрийн дараах хэрэгжилт, гүйцэтгэлийн шатанд хяналт, тайлбар, дэмжлэг хангалтгүй байгаа нь иргэдийн шударга ёсонд итгэх итгэлийг алдагдуулж буй гол хүчин зүйлсийн нэг болж байна. Иймд шударга ёсны хүртээмжийг сайжруулах бодлого, эрх зүйн шинэчлэл нь зөвхөн шүүхийн шатанд бус, бүхэл бүтэн процессын түршид иргэнийг дэмжих, хамгаалах тогтолцоог цогцоор нь бүрдүүлэхэд чиглэх шаардлагатай.

Энэхүү судалгаа нь шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэхэд иргэний нийгмийн байгууллагуудын оролцоо, бодит туршлагад суурилсан судалгаа, нотолгоонд тулгуурласан бодлого боловсруулахын ач холбогдлыг баталгаажуулж, цаашид хууль, бодлогын түвшинд бодит өөрчлөлт хийх үндэслэл болж байна.

Судалгаанд оролцсон нийгмийн бүх бүлгийн санал, дэвшүүлсэн шийдлүүдийг нэгтгэн дүгнэхэд шударга ёсны хүртээмжийг сайжруулахад чиглэсэн дараах үндсэн багц зөвлөмжүүд тодорхойлогдож байна. Эдгээр зөвлөмж нь бүтэц, процесс, санхүү, хандлага, мэдээлэл, технологийн түвшинд харилцан уялдаа бүхий цогц өөрчлөлт хийх шаардлагатайг илэрхийлж байна.

3.3.Зөвлөмж, санал

1.Хүн төвт, хүртээмжтэй шүүхийн үйлчилгээний орчныг бүрдүүлэх: Оролцогчдын зүгээс шүүхийн байр, орчин, үйлчилгээний зохион байгуулалт нь иргэдийн бодит хэрэгцээнд нийцэхгүй байгааг нийтлэг онцолсон. Үүнтэй холбогдуулан:

-шүүхийн барилга байгууламжийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настан, хүүхдэд ээлтэй стандартын дагуу үе шаттайгаар шинэчлэх. Тухайлбал, налуу зам, цахилгаан шат, чиглүүлэх тэмдэглэгээ, хүртээмжтэй ариун цэврийн өрөө, хараа, сонсголын бэрхшээлтэй хүнд зориулсан шийдлийг заавал биелүүлэх стандарт бий болгох.

-хоширогч, шүүгдэгч, гэрч хоорондоо тааралдах эрсдэлийг бууруулах тусгай орц, гарц, хүлээлгийн бүс бий болгох;

-хүүхэд, хүчирхийллийн хохирогчидтой ажиллахад зориулсан аюулгүй, сэтгэл зүйд ээлтэй орчныг тогтолцооны түвшинд бүрдүүлэх.

2.Хууль зүйн болон процессын зохицуулалтыг хялбаршуулах, ойлгомжтой болгох:
Судалгаанд оролцогчид хууль зүйн процесс хэт төвөгтэй, ойлгомжгүй, шат дамжлага ихтэй байгааг шүүхэд хандах гол саад гэж тодорхойлсон. Үүнтэй холбогдуулан:

-иргэдэд зориулсан процессын алхамчилсан, энгийн тайлбар, загвар маягт боловсруулах, процессын явцад асууж иргэн тогтмол мэдээлэл авах боломжтой нэгдсэн веб сайтыг бий болгох. *Тухайлбал*, “Шүүхэд хэрхэн хандах вэ?” заавраар шүүхэд нэхэмжлэл, гомдол гаргах алхам бүрийг энгийн хэлээр тайлбарласан; бичиг баримтын загвар, жишээ; аль шатанд ямар байгууллага хариуцахыг зураг, схемээр харуулсан гэх мэт. Мөн үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах болзол, шалгуур, холбогдох байгууллагын холбоо барих мэдээлэл, байршил, хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээний талаарх мэдээлэл.

-шүүхийн шийдвэр, дараагийн шатны үйл ажиллагааны талаар заавал тайлбар өгөх стандарт тогтоох;

-эвлэрүүлэн зуучлал, нотлох баримт бүрдүүлэлт, шийдвэр гүйцэтгэлийн шатанд иргэдийг чирэгдүүлдэг давхардсан зохицуулалтыг дахин хянах;

-нэг баримт дутсан ч бусдыг нь хүлээн авч, нөхөж бүрдүүлэх боломж олгодог байх;

-шүүхийн бичиг баримтыг энгийн хэлээр тайлбарласан загвар бий болгох, мэдэгдэх хуудас, шийдвэр, тайлбаруудыг ойлгомжтой хэл найруулгаар бэлтгэж сумын төв, багийн мэдээллийн самбарт байрлуулах. Эдгээр нь зөвхөн унших бус харааны бэрхшээлтэй, өндөр настай, насанд хүрээгүй хүмүүс зэрэг нийгмийн бүхий л бүлгийн хүмүүсийн хэрэгцээнд нийцсэн хэлбэртэй байх;

-аймаг, сум, баг, хорооны түвшинд хууль зүйн зөвлөгөө, зөвлөмж өгөх тогтмол хүний нөөц, цахим лавлагааны нэгж байгуулах, үнэ төлбөргүй өмгөөлөгчийн хүртээмжийг нэмэгдүүлэх. Шүүхэд хандах, бичиг баримт бүрдүүлэх, хариу тайлбар гаргах, давж заалдах эрхийн талаар туслалцаа үзүүлэх;

-шүүх бүрд гэрээт хэлмэрчийн жагсаалт баталгаажуулах, хуралдааны үеийн хүртээмжийг нэмэгдүүлэх, дохионы орчуулагч, хадмал орчуулга гэх мэт үйлчилгээг нэвтрүүлэх, онлайн хуралдаанд дохионы хэлмэрч орчуулагчийн үйлчилгээг заавал хамт явагддаг болгох. Шүүхийн хэлмэрч, орчуулагчийг чадавхжуулах. Төлбөргүй байх нөхцөлийг бүрдүүлэх;

-хүүхэд оролцсон хэрэгт хүүхдийн нас, сэтгэлзүйн онцлогт нийцсэн асуулт асуух, хурлын товыг хичээлийн цагтай уялдуулах, сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэхийг процессын заавал биелүүлэх шаардлага болгох;

-хөгжлийн бэрхшээлтэй иргэний үйлчилгээний хэрэгжилтийн явцыг хянах “case manager” үүрэг бүхий нэгж/хариуцагч тодорхойлох, ахмадуудад зориулсан хөтөч ажилтан томилох, сумын захиргаа, багийн төвд хуульч, хуулийн зөвлөх, өмгөөлөгч ажиллуулах.

3.Санхүүгийн дарамтыг бууруулах, хууль зүйн туслалцааны хүртээмжийг нэмэгдүүлэх: Шүүхийн хураамж, зорчих зардал, өмгөөлөгч, хэлмэрч, шинжилгээний зардал нь шударга ёсны хүртээмжид ноцтой саад болж байгааг бүх бүлэг онцолсон. Иймээс:

-үнэ төлбөргүй хууль зүйн туслалцааны хамрах хүрээ, чанар, жигд байдлыг нэмэгдүүлэх; хэлмэрч, орчуулагчийн зардлыг төрөөс даах тогтолцоог тодорхой болгох; нийгмийн эмзэг бүлэгт шүүхийн хураамж, дагалдах зардлын хөнгөлөлт, чөлөөлөлтийн механизмыг өргөжүүлэх;

-ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хөнгөлөлт, чөлөөлөлт олгох. Нэхэмжлэл, давж заалдах шатны улсын тэмдэгтийн хураамжийг нэхэмжлэлийн үнийн дүн бус иргэдийн орлогын түвшинд нийцүүлж, тооцдог байх;

-алслагдсан сумдаас ирэх ахмадуудын тээврийн зардлыг төрөөс тодорхой хувиар нөхөн олгох, нийтийн тээврийн тогтмол шугам, хөнгөлөлттэй үйлчилгээ бий болгох;

-ахмадуудад зориулсан үнэгүй хууль зүйн туслалцаа үзүүлэх тогтолцоог өргөжүүлэх, өмгөөлөгчийн төлбөрийн дээд хязгаар тогтоох;

-тусгай зориулалт бүхий зардлыг шүүхийн төсөвт тусгах. Хууль зүй, дотоод хэргийн яам, Сангийн яам, Шүүхийн ерөнхий зөвлөлийн төсвийн багцад “хүртээмжийн үйлчилгээний зардал” гэсэн бие даасан ангилал бий болгох. Хэлмэрчийн үйлчилгээ, танхимын тохируулга, мэдээллийн хүртээмж, сургалтын зардлыг жил бүр тогтвортой тусгах.

4.Хүний эрхэд суурилсан хандлага, харилцааны соёлыг төлөвшүүлэх: Оролцогчид шүүх, хууль сахиулах байгууллагын ажилтнуудын хандлага, харилцааны соёл нь шүүхэд итгэх итгэлд шүүд нөлөөлж байгааг онцолсон. Үүнтэй холбоотойгоор:

-шүүгч, шүүхийн ажилтнууд, мөрдөгч, прокурор нарт зориулсан хүний эрх, жендер, хүүхэд хамгаалал, хохирогч төвт хандлагын сургалтыг тогтмол зохион байгуулах;

-буруутгах өнгө аяс, ялгаварлан гадуурхалтад хариуцлага тооцох дотоод хяналтын механизм бий болгох.

-хэлний бэрхшээлийг шийдэх. Шүүхийн хуралдаанд казах, дөрвөд, захчин, урианхай зэрэг нутгийн хэлээр ярьдаг иргэд оролцох үед мэргэшсэн хэлмэрч томилох тогтолцоог хуульчилж, санхүүжүүлэх. Баян-Өлгий, Ховд, Увс зэрэг аймагт казах хэлээр орчуулсан шүүхийн мэдээлэл, зааварчилгаа түгээх. Шүүхийн цахим платформ дээр олон хэлний сонголт нэвтрүүлэх;

-хөгжлийн бэрхшээлийн төрлүүдэд тохируулан харилцах арга зүй, ойлгомжтой тайлбар өгөх, шаардлагатай үед дэмжлэг үзүүлэх дадлага бүхий сургалт явуулах, Хэлний хүртээмжийг сайжруулах зорилгоор шүүхийн ажилтнуудад дохионы хэлний сүүр мэдлэг олгох тогтмол сургалт зохион байгуулах, Шүүхийн сургалтын хөтөлбөрт case-based simulation болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд оролцсон туршлагын дадлага (experiential learning)-ыг жишиг аргачлал болгон нэвтрүүлж, бодит нөхцөлд ажиллах ур чадварыг хөгжүүлэх;

-мэдээллийн нууцлал хамгаалах, хувийн мэдээллийн нууцлалыг хамгаалах журмыг боловсронгуй болгож, задруулсан албан хаагчдад хариуцлага тооцдог болох;

-хүчирхийлэл үйлдэгчийг хорих ангиас суллагдахад нь хохирогчид урьдчилан мэдэгддэг болох.

5.Мэдээллийн ил тод, хүртээмжтэй байдлыг сайжруулах: Шүүхийн үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл ойлгомжгүй, хүртээмж муутай байгаа нь иргэдийг эрхээ хэрэгжүүлэхэд саад болж байна. Иймээс:

-шүүхийн цахим болон танхимын үйлчилгээний мэдээллийг энгийн хэллэг, олон хэл, олон хэлбэрээр хүргэх;

-ахмадуудыг санхүүгийн луйвар, зээлийн дарамтаас хамгаалах сургалт, зөвлөгөө тогтмол өгөх. Бүх нийтийн эрх зүйн боловсролын цахим суваг, радио/телевизийн нэвтрүүлэг, цаасан хувилбар зэрэг олон төрлийн хэлбэрийг ашиглан дээшлүүлэх; эрх зүйн мэдээллийн дийлэнх нь цахимаар хүрж байгаа тул ахмадуудын цахим хэрэглээний чадварыг нэмэгдүүлэх, үүнтэй холбоотойгоор сургалт зохион байгуулах;

-албан хаагчдын мэдээлэл түгээх чадварыг сайжруулах. Иргэдийн асуултад шуурхай, тодорхой хариу өгөх тогтолцоо бий болгох.

6.Технологи, цахим шийдлийг ялгаваргүй, хүртээмжтэй нэвтрүүлэх: Цахимжилт нь шударга ёсны хүртээмжийг нэмэгдүүлэх боломжтой ч бүх бүлэгт адил тэгш хүрч чадахгүй байгааг оролцогчид тэмдэглэсэн. Үүнтэй холбогдуулан:

-цахим шүүхийн үйлчилгээтэй зэрэгцэн танхимын, биечлэн үйлчилгээний сонголтыг хадгалах, цахим системийг хөгжүүлэхдээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн стандарт мөрдөх; цахим үйлчилгээ ашиглахад туслах хөтөч, зөвлөх механизм бий болгох.

-сумын төвүүдэд цахим хуралд зориулсан тусгай өрөө, төхөөрөмж, интернэт, мэргэжлийн зөвлөх бүхий дэмжлэгийн төвүүдийг байгуулах;

-технологи ба иргэний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх. Оролцогчдоос иргэний эрх зүйн боловсролыг дээшлүүлэх хүрээнд эрх зүйн биет бус тогтолцоо буюу нэгдсэн эрх зүйн мэдээллийн цахим болон пэйж хуудсыг хөгжүүлэх шаардлагатай. *Тодруулбал*, иргэдэд биет бус байдлаар буюу цахим орчинд, зайнаас анхан шатны хамгийн хэрэгцээт, энгийн үг хэллэг бүхий хууль зүйн зөвлөгөө, мэдээлэл өгөх мэдээллийн технологи, харилцаа холбооны дэд бүтцийг бий болгох шаардлагатай. Энэхүү цахим хуудасны үйл ажиллагааг нь тогтмолжуулах, шинэчлэлт өөрчлөлтийг тухай бүр хийж байхад анхаарах. Үүнийг зөвхөн албаны шугамаар бус, иргэний нийгмийн байгууллагаар гэрээний үндсэн дээр гүйцэтгүүлдэг байх нь үр дүнтэй бас зохимжтой юм.

ДӨРӨВ. СУДАЛГААНЫ ҮР ДҮНД ИРГЭДИЙН ТОДОРХОЙЛСОН ШУДАРГА ЁСНЫ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ (ДЭЛГЭРЭНГҮЙ ХҮСНЭГТ БАЙДЛААР)

Хүснэгт 2. Бүтцийн шинжтэй бэрхшээл: Тухайн бүс нутагт шүүх байхгүй байх, хөгжлийн бэрхшээлтэй, өндөр настай хүний хэрэгцээ шаардлагад нийцээгүй барилга байгууламж гэх мэт

Ахмад настан	<ul style="list-style-type: none"> ● Байршил. Шүүхийн байгууллага хамгийн бага засаг захиргааны нэгж болох сум, багт байхгүй тул аймгийн төв рүү 100-300 км зам туулан очих шаардлагатай болдог. ● Алслагдсан байршлын тээврийн хүндрэл. Нийтийн тээвэр тогтмол бус, хувийн унаанд найдах шаардлагатай болдог. ● Шүүхийн байрны стандарт. Шүүхийн байгууллагын байр нь хуучирсны улмаас стандарт хангахаа больсон бөгөөд налуу зам, шат, ариун цэврийн өрөө зэрэг ахмад, хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй орчин бүрдээгүй.
Хөдөө орон нутгийн иргэд	<ul style="list-style-type: none"> ● Байршил. Баруун таван аймаг нь өндөр уулын бүсэд оршдог тул замын бартаа ихтэй, сүмдын төвүүд алслагдсан байршилтай. Шүүхийн бүтэц нь ихэнх аймагт төвлөрсөн байдалтай байдаг. Завхан болон Ховд аймагт шүүхийн үйлчилгээ хоёр байршилд хүрдэг бол Увс, Говь-Алтай, Баян-Өлгий аймагт зөвхөн аймгийн төвд төвлөрсөн ганц шүүхийн байршилтай. Аймгийн төвд хүрэхийн тулд 100–400 км зам туулах шаардлагатай сум олон бөгөөд тээврийн зардал, замын нөхцөл, цаг хугацааны хувьд иргэдэд маш хүндрэлтэй нөхцөл үүсгэдэг.
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	<ul style="list-style-type: none"> ● Шүүхийн байрны стандарт. Хараа болон тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэд шүүхийн байр, хүлээлгийн танхим, хуралдааны танхимд нэвтрэхдээ бие даан үйлчлүүлэхэд хүндрэлтэй. Налуу зам, шатны гарц, чиглүүлэг, тэмдэглэгээ хангалтгүйгээс болж бусдын тусламжид найдах хэрэг гардаг.
Хүүхэд	<ul style="list-style-type: none"> ● Байршил. Анхан шатны тойргийн шүүхүүдийн байрлалаас хамаараад дүүрэгт нь шүүх байхгүй бол хувийн унаагаар эсхүл 2-3 удаа нийтийн тээврээр дамжин очих шаардлагатай болдог. ● Шүүхийн байрны стандарт. Шүүхийн байрны хаалга, шат, ариун цэврийн өрөө ашиглахад хэцүү, материаллаг орчны хүртээмж, тохируулга байхгүй. Сум дундын шүүх дотроо ариун цэврийн өрөөтэй ч гадна байрлах модон жорлонд ор гэдэг бөгөөд холбогдогчид гадаа салхилж зогсож байхад хүүхэд хажуугаар нь явж жорлон орох шаардлага гардаг талаар оролцогчид ярьсан. Түүнчлэн хувийн машинтай очиход автомашины зогсоол байдаггүй. ● Хүүхдэд зориулсан тусгай өрөө, орц гарцын шийдэл байхгүй. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхүүд В1 давхартаа цагдан хорих байртай байдаг. Шүүхийн байрны орц, гарц нь ганц л байдаг тул хохирогч/даван туулагч хүүхдүүд холбогдогчтой таарах нөхцөл бүрддэг. Үүнээс үүдэн тухайн хүүхдүүд сэтгэл зүйн хямралд орох, түгшүүр сэдрэх тохиолдлууд гардаг. 2005-2008 оны хооронд төслөөр хүүхдээс мэдүүлэг авах зориулалттай 30 орчим өрөөг бий болгож байсан ч эдгээрийн ажиллагаа хангалтгүй байна. ● Уур амьсгал. Шүүхийн байрны уур амьсгал хүүхэд гэлтгүй насанд

	хүрсэн хүн ороход ч сүрдмээр, айдас төрүүлэхүйц байдаг нь сэтгэл түгшил, айдсыг төрүүлдэг.
Залуучууд	<ul style="list-style-type: none"> ● Бүтцийн шинжтэй бэрхшээл тодорхойлоогүй. Залуучуудын бүлэг нь шүүхэд хандах, хуулийн асуудлаар маргаан үүсгэх туршлага харьцангуй багатай нь ажиглагдаж байсан талаар Бүлгийн судалгаанд дурджээ. Судалгаанд оролцогчдын ердөө 8 хувь нь л өөрийгөө шүүхийн талаар мэдлэг сайн, маш сайн гэж үнэлсэн бол 45 хувь нь дунд зэрэг, 47 хувь нь мэдлэггүй гэж үнэлжээ. Иймд өөрсдийн туршлага гэхээс илүү эргэн тойрны хүмүүсийн туршлагад үндэслэн судалгаанд хамрагдсан байна.
Эмэгтэйчүүд	<ul style="list-style-type: none"> ● Шүүхийн зохион байгуулалтын замбараагүй байдал. Хялбар ажиллагааны (ганцхан) шүүх үйл ажиллагаа явуулж эхэлснээр тус шүүхээр хэрэг шийдвэрлүүлэх хүмүүсийн хувьд шүүх холдсон. Мөн хялбар ажиллагааны шүүхийн нэг шүүгчийн ачаалал өндөр. Шүүхүүд тойргийн зарчимд шилжсэнээр шүүгчид өөр өөр шүүх дээр байрлаж ажиллаж байгаатай холбоотой шүүх, шүүгчээ хайж явах, хэрэгтэй танилцах гэхээр шүүгч өөр шүүх рүү аваад явсан байх зэрэг замбараагүй байдал үүссэн. ● Шүүхийн байрны стандарт. Налуу зам нь хэлбэр төдий, лифтгүй, коридорт хоорондоо зөрөх зайгүй зэрэг асуудалтай. Хурлын танхим, өрөөний хаалганы гаднаас хүний ярьж байгаа нь чөлөөтэй сонсогддог, нууцлал хангах боломжгүй орчинтой байдаг. ● Тусгай орц, гарцын шийдэл байхгүй. Хэргийн бүх оролцогч ганцхан хаалгаар бүгд орж гардаг. Хохирогч, шүүгдэгч тааралдах боломжийг ихэсгэдэг.
Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон иргэд	<ul style="list-style-type: none"> ● Шүүхийн байршил, зай хол ● Тусгай орц, гарцын шийдэл байхгүй. Хохирогч холбогдогч нэг орчинд таарах, дарамт, айдас үүсдэг.

Хүснэгт 3. Хууль зүйн болон процессын шинжтэй бэрхшээл: Хууль, эрх зүйн зохицуулалт нь бэрхшээл үүсгэдэг, бичиг баримт бүрдүүлэхэд төвөгтэй, ойлгомжгүй байдал гэх мэт

Ахмад настан	<ul style="list-style-type: none"> ● Бичиг баримт. Бичиг баримт бүрдүүлэх төвөгтэй, шат дамжлага олон. Нэг бичиг баримт дутвал бүх үйл явц зогсдог. ● Ойлгомжгүй үг хэллэг. Хууль зүйн хэллэг хэт мэргэжлийн, ойлгомжгүй. ● Мэдээлэл хангалгүй. Иргэд хаана, ямар шат дамжлагаар хандахаа мэддэггүй буюу иргэдийн эрх зүйн мэдлэг, анхан шатны мэдээлэл муу. ● Шүүхийн процесс. Шүүхийн шийдвэр удаашралтай, шат хооронд зөрчилтэй. ● Шүүхийн дараах процесс. Шүүхийн шийдвэр хэрэгжихгүй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага дээр гацдаг бөгөөд хохирол бодитой тогтоогддоггүй, барагдуулалт маш муу, удаан үргэлжилдэг. Хариуцлагын механизм үйлчилдэггүй.
Хөдөө орон нутгийн иргэд	<ul style="list-style-type: none"> ● Хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ хангалтгүй. Баруун бүсийн аймгуудын түүвэр судалгаанаас үзэхэд олон сум, багт өмгөөлөгч, хуульчийн байнгын үйлчилгээ байхгүй, зарим тохиолдолд огт

	<p>хүрэлцдэггүй. Иргэд шүүхэд хандахдаа эрхээ хамгаалах мэргэжлийн дэмжлэггүй, хууль зүйн баримт бичиг боловсруулах, хариу тайлбар гаргах, гомдол бичих зэрэгт бие даан оролцох боломжгүй байна. Энэ нь хууль зүйн оролцооны тэгш байдал, шударга шүүхийн зарчимд сөргөөр нөлөөлдөг.</p>
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	<ul style="list-style-type: none"> ● Хууль зүйн мэргэжлийн үйлчилгээ хангалтгүй. Үнэ төлбөргүй үйлчилгээ олж болох зохицуулалттай ч хүний нөөц, мэргэшлийн чадавх бага, орон нутагт төв салбар хүрэлцээгүй, “гэрээр очиж үйлчилгээ үзүүлэх” механизм хэрэгждэггүй. ● Шийдвэрийн хэрэгжилтийн шат дахь дэмжлэг дутмаг. Шүүхийн шийдвэр гарсны дараа иргэн шийдвэрийн утга, хэрэгжүүлэх дарааллыг ойлгоход хүндрэлтэй байгаа нь нийтлэг байв. Шүүхийн байгууллагаас дараах шатны мэдээлэл, заавар, дэмжлэг үзүүлэх үйлчилгээ (жишээлбэл, баримт бичгийн загвар, алхамчилсан зөвлөмж, холбон зуучлах үйлчилгээ) хангалтгүй.
Хүүхэд	<ul style="list-style-type: none"> ● Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад мэдээллийг бүрэн тайлбарлаж ойлгуулдаггүй. Хүүхэд оролцож буй аливаа хэрэг маргааны явцад шүүхийн зүгээс хүүхдэд эрх, үүрэг танилцуулах, асуулт асуухдаа хүүхдийн нас, сэтгэхүйн онцлог болон тухайн үеийн сэтгэл зүйн байдалд тохирсон байдлаар тайлбарлаж, асуудаггүй. Зөвхөн эрх, үүрэг танилцуулах бүс бүхий л үйл ажиллагаанд хүүхэд, тэдгээрийн хууль ёсны төлөөлөгчид мэдээлэл хүргэх, болж буй процессыг тайлбарлахдаа хэт ерөнхий, формаль байдлаар, хуулийн үг хэллэгээр тайлбарладаг. Эрүүгийн хуулийн 12.2-т заасан гэмт хэрэг үйлдсэн гэж анхан шатны шүүхээс ял авсан насанд хүрээгүй хүүхэд, түүний гэр бүлд давж заалдах эрхийн талаар хангалттай тайлбарлаагүйгээс давж заалдах хугацаа өнгөрсөн тохиолдол гарч байжээ. ● Шүүх хурлын тов. Хүүхэд оролцох шүүх хурлын товыг хүүхдийн хичээлийн цагаас зөрүүлж, түүнийг харгалзан үзэж тогтоодоггүй. Хурлын товыг цөөн хоногийн өмнө мэдэгдсэнтэй холбоотойгоор хүүхдийн сэтгэл зүйг хангалттай бэлдэж амждаггүй. Хурлын товыг оролцогч хүн бүрд мэдэгддэггүйгээс мэдээллийн зөрүү үүсдэг. ● Мэргэжлийн ёс зүй. Хэргийн нөгөө талын өмгөөлөгчдийн зүгээс үйл явдлыг нарийн яриулах гэж оролдох, санаатайгаар сандаргах үг хэллэг ашигладаг.
Залуучууд	<ul style="list-style-type: none"> ● Удаашралтай, гэнэтийн үйл явц. Шүүхийн процесс удаашралтай, гэнэтийн байдлаар дуудах зэрэг нь залхаасан тул дахин шүүхэд хандах сонирхолгүй болсон гэжээ.
Эмэгтэйчүүд	<ul style="list-style-type: none"> ● Нотлох баримттай холбоотой процесс удаашрал. Нотлох баримт шүүхээр гаргуулах гэхээр хугацаа их алддаг. “Хуулбар үнэн” дарсан байхад заавал нотариат шаарддаг. Аливаа байгууллагууд нотлох баримтыг заавал өмгөөлөгчөөр эсхүл шүүхээр дамжуулж ав гэж шаарддаг. Нотлох баримтын шаардлага хангаагүй гэж олон буцаадаг. ● Эвлэрүүлэн зуучлал. Бараг нэг илүү шат болоод байдаг. ● Хүчирхийллийн харилцаа нотлох. Хүчирхийллийн харилцаатай байсныг нотлоход зөвхөн өмнө цагдаад дуудлага өгч, зөрчил, эрүүгийн хэрэгж үүсгүүлж байсан эсэхийг л нотлох баримт гэж хүлээж авдаг. Бусдыг нотлох баримтын хэмжээнд үнэлдэггүй.

	<ul style="list-style-type: none"> ● Шүүхийн шийдвэр, түүний биелэлт. Шүүх шийдвэрээ сайн тайлбарлаж өгдөггүй. Шийдвэрийг сайн дураар биелүүлэхгүй бол хүсэлтээ шүүгчид гаргаад захирамж гаргуулж, гүйцэтгэх хуудас бичүүлнэ гэдгийг хүн бүр мэдэхгүй. Үүнийг тайлбарлаж өгдөггүй. ● Оргон зайлсны улмаас удаашрах. Гэмт хэргийн тухайд холбогдогчид шүүхийн шатанд оргон зайлах тохиолдол гардаг. Үүнээс болж хэрэг удааширдаг. ● Хохирогчийг хамгаалах. Хохирогчийг түр хамгаалах байр, бусад үйлчилгээнд холбох зохицуулалт хийдэггүй. ● Хэлмэрчийн асуудал. Хэл, сонсголын бэрхшээлтэй хүмүүс нэхэмжлэл гаргах, түүнийгээ шүүхэд өгөхөд асуудал үүсдэг. Шүүхүүд дээр тайлбарлаж өгөх хөтөч байдаггүй. Нэг маргаан дээр холбогдогч, гэрч, хохирогч бүгд хэл, сонсголын бэрхшээлтэй байгаад нийт 3 хэлмэрч хэрэг болсон боловч олдоогүйгээс шалтгаалаад 2 жил гаран сунжирч байсан. Дохионы хэлмэрч орчуулагчдын холбоо ТББ-д хандахад шүүх зардлаа гаргаж өгөөгүй гээд шүү хуралд оролцож өгөөгүй. Дохионы хэлмэрчдийг мэргэшүүлэхгүй бол хуулийн үг хэллэгээр дохионы хэлмэрч хийхэд учир дутагдалтай байдаг.
Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон иргэд	<ul style="list-style-type: none"> ● Мэдээлэл өгдөггүй. Хүчирхийлэл үйлдэгч ял эдэлж дуусаад суллагдах үед хохирогчдод урьдчилан мэдэгддэггүй тул дахин дарамт, сүрдүүлэгт автдаг. ● Эвлэрүүлэн зуучлал. 108 болон 102-т дуудлага өгч байсан гэж хэлээд байхад нотлох баримтгүй гээд эвлэрүүлэн зуучлал руу явуулсан.

Хүснэгт 4. Санхүүгийн шинжтэй бэрхшээл: Шүүхийн хураамж, зорчих зардал, хууль зүйн үйлчилгээний зардал гэх мэт

Ахмад настан	<ul style="list-style-type: none"> ● Шүүхийн хураамж, зардал. Шүүхийн хураамж өндөр. ● Хууль зүйн үйлчилгээний зардал. Өмгөөлөгчийн төлбөр өндөр бөгөөд мөн нотариат, шинжилгээ, архивын зардал нэмэгддэг. ● Бусад зардал. Зорчих зардал их, олон удаа явах шаардлага гардгаас гадна байр, хоол, бичиг баримтын нэмэлт зардал гардаг. ● Улмаар дээрх олон төрлийн зардалд ахмадуудын орлого (тэтгэвэр) хүрэлцдэггүй.
Хөдөө орон нутгийн иргэд	<ul style="list-style-type: none"> ● Санхүүгийн шинжтэй бэрхшээл тайланд тодорхойлоогүй.
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	<ul style="list-style-type: none"> ● Хэлмэрч, орчуулагчийн зардал. Хэлмэрч, орчуулагчийн үйлчилгээний зардлын эх үүсвэр тодорхойгүй байдал нь хүртээмжийг бууруулдаг. ● Тухайлсан төсөв байхгүй. Хүртээмжийн арга хэмжээнд зориулсан төсвийн ангилал байхгүй. ХЗДХЯ, ШЕЗ гэх зэрэг гол салбар байгууллагуудын жил бүрийн төсөвт хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хүрэх үйлчилгээ, сургалт, орчны сайжруулалт, хэлмэрчийн үйлчилгээ зэрэгт зориулсан санхүүжилт тусгагддаггүй.
Хүүхэд	<ul style="list-style-type: none"> ● Зардлыг нэг процесс ажиллагаагаар шийддэггүй. Тээврийн зардал, шүүхийн шинжилгээний газар очих, сэтгэцэд учирсан хохирол тогтоолгох, мэдүүлэг өгөх зэргээр зардал маш их гардаг.

	<p>Гэтэл заавал баримтаар нотлох шаардлага үүсдэг нь олон удаагийн зардал бүрийг нотлоход хүндрэлтэй байдаг. Түүнчлэн эрүүгийн процесс ажиллагаагаар зардлаа иргэний журмаар нэхэмжлэх эрх нь нээлттэй гээд үлдээдэг нь хохирсон хүмүүс зардлаа нөхөн төлүүлж чадахгүйд хүргэдэг.</p> <ul style="list-style-type: none"> ● Хууль зүйн үйлчилгээний зардал. Гэмт хэргийн хохирогч/холбогдогч хүүхдүүд, тэдгээрийн асран хамгаалагчид нь ямар тохиолдолд хууль зүйн үнэ төлбөргүй туслалцаа авах боломжтой талаарх мэдээлэл харилцан адилгүй байдаг. Зарим тохиолдолд ийм үйлчилгээ авч чаддаг бол зарим тохиолдолд чаддаггүй. Мөн томилж өгсөн өмгөөлөгчийн мэргэжлийн үр чадвар харилцан адилгүй байдаг. Улсын өмгөөлөгчид давхар ар гэрээс нь мөнгө авдаг талаар нэлээд сонсож байсан гэж нэгэн оролцогч судалгааны явцад ярьжээ.
Залуучууд	<ul style="list-style-type: none"> ● Шүүхэд хандахад олон төрлийн зардлын нийлбэр дүн нь санхүүгийн ачаалал үүсгэдэг.
Эмэгтэйчүүд	<ul style="list-style-type: none"> ● Сэтгэцэд учирсан хохирол. Сэтгэцэд учирсан хохирол нэхэмжилж болдог болсон ч маш их нотлох баримт шаарддаг. Шүүх эмнэлэг дээр очиход Монголд энэ төрлийн 2 шинжээч байдаг тул ачаалал ихтэй гээд 2 сар орчим хүлээсэн. Мөрдөгч нар ч сэтгэцэд учирсан хохирол тогтоолгоно гэвэл үдна шүү гэж айлгадаг болсон.
Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон иргэд	<ul style="list-style-type: none"> ● Зардал өндөртэй. ● Үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авахад олон бичиг баримт бүрдүүлдэг.

Хүснэгт 5. Нийгмийн болон соёлын шинжтэй бэрхшээл: Нийгмийн гадуурхалт, үл тоох, хэлний бэрхшээл, итгэлцлийн дутагдал гэх мэт

Ахмад настан	<ul style="list-style-type: none"> ● Харилцаа. Ахмад настан, эмэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн санал, хүсэлт, гомдлыг үл тоох, гадуурхаж ханддаг. ● Хандлага. Төрийн байгууллагын албан хаагчдын биеэ тоосон, дээрэнгүй байдал, ахмад настныг үл хүндэтгэх, үл тоомсорлох хандлага. Дийлэнх ажилчид нь залуус байдаг бөгөөд залуус ахмадуудыг хоцрогдсон, хэрэгцээгүй гэж үзэх хандлагатай болсон. Улмаар ахмадуудын ганцаардал, нийгмийн харилцаанаас тусгаарлагдах байдал их. ● Шүүхэд итгэх итгэл. Нийгмийн итгэлцэл сул, төрд итгэх итгэл буурсан. ● Хэлний болон ойлголтын бэрхшээл. Мэргэжлийн үг хэллэг, гадаад хэл давамгайлах болсон.
Хөдөө орон нутгийн иргэд	<ul style="list-style-type: none"> ● Хэлний бэрхшээл. Угсаатан, ястны цөөнх бүлэг, жишээ нь Баян-Өлгий аймгийн казах иргэд монгол хэлний мэдлэг хязгаарлагдмал тул төрийн үйлчилгээ авах, шүүх хуралдаанд оролцоход хүндрэлтэй. ● Хандлага. Зарим иргэд шүүхэд очиход “шүүд баривчилна”, “хорино”, “загнана” “нэр хүндэд халтай”, “шүүхэд зөвхөн гэмт хэрэгтнүүд л очдог” гэж айдаг. Энэ нь хууль зүйн мэдээллийн хомсдол, өмнөх сөрөг туршлага, соёлын хэвшмэл ойлголт, орон нутгийн ам дамжсан ярианаас үүдэлтэй. Ийм айдас нь иргэдийг

	<p>шүүхэд очихоос татгалзах, эрхээ хамгаалах боломжоо алдах, асуудлаа албан ёсоор шийдвэрлүүлэхгүй байх шалтгаан болдог.</p>
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	<ul style="list-style-type: none"> ● Хэлний бэрхшээл. Сонсголын бэрхшээлтэй оролцогчдын хувьд хэлмэрчийн үйлчилгээ байнгын бус, заримдаа бүр байхгүй байжээ. Үүнээс үүдэж тэд шүүх хуралдааны үеийн хэлэлцүүлэг, шийдвэрийн утга санааг бүрэн ойлгох боломжгүй байдаг. Мөн оюуны хөгжлийн бэрхшээлтэй оролцогчид “шүүхийн бичиг баримт, тайлбарууд хэт хүнд, ойлгомжгүй байсан” гэж тэмдэглэсэн нь хэлний хүртээмжийн бодит дутагдал юм. Хэт мэргэжлийн, хууль зүйн нэр томьёо давамгайлсан хэллэг нь оролцооны бодит тэгш байдлыг алдагдуулж, иргэнийг шийдвэр гаргах үйл явцаас зайлуулж байгаа нэг хэлбэр болж байна. ● Хандлага. Оролцогчдын дийлэнх нь шүүхийн ажилтнуудын хандлагыг “хүйтэн, хөндий, үл тоомсорлосон” гэж тодорхойлжээ. Зарим тохиолдолд ажилтнуудын харилцаа ойлгомжгүй, эсвэл хэт товч, хайхрамжгүй байснаас иргэдийн итгэл буурч, дахин хандахаас зайлсхийх сэтгэлзүй үүсдэг байна.
Хүүхэд	<ul style="list-style-type: none"> ● Харилцаа. Шүүх хуралдааны явцад хүүхдүүдэд хүндэтгэлтэй, үзэл бодлыг нь сонсдог боловч, шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын ажилтнууд, мөрдөгчид нийтлэгээрээ захирангуй, ширүүн байдаг. Холбогдогчоор оролцож буй хүүхдүүдэд бүр илүү ширүүн, захирангуй загнах тохиолдол ажиглагддаг. Шүүх, прокурор, цагдаагийн байгууллагын ажилтнууд, мөрдөгчдийн хүүхдэд хүндэтгэлтэй хандах байдлыг оролцогчид 1-5 хооронд үнэлэхдээ 3 гэж, харин хүүхдийн сэтгэл зүйн байдлыг хүндэтгэж, айдас түгшүүрийг ойлгож мэдрэмжтэй хандах талыг 2-3 оноогоор үнэлсэн. ● Буруутгах өнгө аяс. Ураг төрлийн бэлгийн хүчирхийллийн үед ээжийг буруутгах, болзооны эсвэл олон холбогдогчтой хэрэгт хохирогчийн буруутгах өнгө аястай байдаг. Шүүх хурлын үед шүүгч “Чи хойд аавыгаа гүтгээд байгаа юм биш үү?” гэж асууж байсан бөгөөд хурлын дараа хүүхэд “Нэг шүүгч яалт ч үгүй надад дургүй байна” гэж хэлж байсан тохиолдол гарсан талаар судалгаанд оролцогч ярьжээ.
Залуучууд	<ul style="list-style-type: none"> ● Эцэг эхчүүд багаас буруу ойлголт суулгадаг. Эцэг эхчүүд багаас шүүх бол ял оноодог, хэрэгт орсон хүн л очдог гэсэн хандлагыг суулгасан. ● Албан тушаалтнуудын сөрөг хандлага. Аливаа албан тушаалтнууд залуу хүн учраас үл тоох, дээрэнгүй, ялгаварлаж харьцах, буруутгах хандлага нийтлэг байдаг. Тохиролцож, зөвшилцөхийг санал болгодог. Залуучуудын бүлэг утсаа хулгайд алдах, скүтертэй явж байгаад осолдох г.м зүйл тохиолдсоноор анх удаа хууль, шүүхийн байгууллагад хандах нь түгээмэл байдаг бөгөөд харин энэ үед хууль шүүхийн байгууллагын ажилтнууд үл тоох болон бусад сөрөг хандлага үзүүлснээр залуучууд шууд хууль шүүхийн байгууллагад итгэх итгэлгүй болох нь бий. Судалгаанд оролцогчдын 42 хувь нь Монгол Улсын шүүх шударгаар шийдвэр гаргадаг гэдэгт итгэдэггүй гэж хариулжээ.
Эмэгтэйчүүд	<ul style="list-style-type: none"> ● Дохионы хэлмэрчдийн мэргэжлийн ёс зүй. Бэлгийн хүчирхийллийн хохирогчийн хэлмэрчээр оролцоод хурал дээд

	<p>инээж ярьж байсан тохиолдолд гарч байсан. Хүний нууц задруулдаг. Хөдөө орон нутагт бол хэлмэрчийн асуудал бүр хэцүү болдог.</p> <ul style="list-style-type: none"> ● Буруутгах өнгө аяс. Хохирогчийг буруутгах хандлага хэргийн бусад оролцогчдод байсаар байгаа.
Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон иргэд	<ul style="list-style-type: none"> ● Шүүхийн ажилтнуудын цааргалсан байдал. Шүүхэд очиход аятайхан тайлбарлаад өгчих хүн шүүхээс олддоггүй. Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бүр шүүх рүү зүглээд ч хэрэггүй. ● Буруутгах өнгө аяс. Шүүгч, шүүгчийн туслах зэргээс буруутгасан өнгө аяс илэрдэг. Шүүх хуралд өмгөөлөгчтэй орсон тохиолдолд энэ нь арай гайгүй байдаг. Хууль зүйн туслалцааны төв дээр нэхэмжлэл бичүүлэхээр очиход “мал шиг ямар олуулаа явдаг юм” гэж доромжилсон (4 хүүхэдтэйгээ явж байсан).

Хүснэгт 6. Захиргааны шинжтэй бэрхшээл: Үйл ажиллагааны удаашрал, тодорхой бус байдал гэх мэт

Ахмад настан	<ul style="list-style-type: none"> ● Технологи, цахимжилт дагасан бэрхшээлийг өөрөөр ойлгож тодорхойлсон. Үүнд: <ul style="list-style-type: none"> ○ Албан тушаалтнуудын ялгавартай, танил талд үйлчилсэн хандлага, ● Иргэд хэрэг, ямар шатанд явж байгааг мэдэх боломжгүй, мэдээлэл авахад хүндрэлтэй гэжээ.
Хөдөө орон нутгийн иргэд	<ul style="list-style-type: none"> ● Захиргааны шинжтэй бэрхшээл тайланд тодорхойлоогүй.
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	<ul style="list-style-type: none"> ● Шүүхийн ажилтнуудын хандлага. Шүүхийн ажилтнуудын мэдлэг, иргэдтэй харилцах чадавх сул. ● Шүүхийн үйл ажиллагаанд оролцох боломж хомс. Өргөдөл, гомдол хүлээн авах ажилтан дохионы хэл мэдэхгүй, буруу ойлголт авдаг. Хуралдааны утга, процессыг ойлгоход хүндрэлтэй, орчуулагч, тайлбарлагч дэмжлэггүй.
Хүүхэд	<ul style="list-style-type: none"> ● Хэрэг шийдвэрлэх хугацаа. Онц хүнд гэмт хэргийн тухайд холбогдогч тал хэрэг шийдвэрлэх хугацааг аль болох сунжруулах сонирхолтой байдаг. Хэдийгээр хуульд заасан үндэслэлээр хурлыг хойшлуулсаар байдаг ч энэ нь хохирогч, тэдний асран хамгаалагчдыг залхаадаг. Мөн тодорхой мэдээлэл өгдөггүй, ойлгомжгүй байдал нь залхаадаг. ● Шүүгчийн туслахын үйл ажиллагаа. Шүүгчийн туслахууд хэргийн оролцогчдынхоо нөхцөл байдалд тохируулан мэдрэмжтэй хандах мэдээллээр хангах ёстой. Гэвч энэ байдал нь хүнээс шалтгаалсан байгаад байдаг.
Залуучууд	<ul style="list-style-type: none"> ● Хохирол барагдуулах үйл явц удаан.
Эмэгтэйчүүд	<ul style="list-style-type: none"> ● Шүүх хурал хойшлох. Шүүх хурал маш их хойшилдог. ● Шүүх мэдээллээр хангах ажил маш муу хийдэг. ● Шүүх дээр хамгаалалт муу. Гэр бүлийн маргаанаас гараад ирэхэд цохиод авах тохиолдол гардаг. Гэрч хохирогчийн хамгаалах Тахарын алба ажиллаж байхад маш давуу талтай байсан.

<p>Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон иргэд</p>	<ul style="list-style-type: none"> ● Аюулгүй байдлыг хангаж чаддаггүй. Шүүх дээр очиход байнгын айдастай байдаг. Нүдний шил зүүгээд, хувцсаа аль болох солиод очдог. Иргэний шүүхэд цагдаа байдаггүй тул заримдаа өмгөөлөгчөөрөө бараг хамгаалалт хийдэг. Шүүх хуралдаан завсарласан үед дарамтлах, заналхийлэх тохиолдол гардаг. Шүүх хурлын дараа араас дагаж ирээд дарамталсан тохиолдол гарсан. ● Нууцлал задруулдаг. Төрийн байгууллагууд хувийн мэдээлэл маш их задруулдаг. Жишээ нь хорооны нийгмийн ажилтан 108-д өгсөн мэдээллийг бүгдийг нь бусад гэр бүлийн хамааралтай хүнд өгчихсөн байсан. Одоогоор түр хамгаалах байранд байгаа гээд учраа хэлээд байхад хавтаст хэргийн аливаа материал, шийдвэр дээр хаяг, утас биччихсэн түүгээр мөрдөөд хүрээд ирэх тохиолдол бий.
---------------------------------------------------	-----------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Хүснэгт 7. Мэдээллийн хүртээмжтэй холбоотой бэрхшээл: Хууль, эрх зүйн мэдээлэл, боловсролын хүртээмж гэх мэт

<p>Ахмад настан</p>	<ul style="list-style-type: none"> ● Цахимаар л мэдээлэл хүргэх болсон нь хүртээмж муу. Ахмадуудын цахим хэрэглээний чадвар сул, ухаалаг утас, компьютер ашиглахад хүндрэлтэй. Цахим үйлчилгээ зөвхөн залуу үе, дижитал хэрэглэгчдэд ээлтэй, ахмадууд орхигддог. Мөн хөдөө орон нутгийн ахмадууд интернэт сүлжээ сул, төхөөрөмжийн хүчин чадал багатай байдаг. ● Баримт бичгийн давхардал. Цахим үйлчилгээ нэмэгдэхийн хэрээр цаасан бичиг баримт улам ихэсдэг, давхардал бий болдог. ● Баталгаагүй мэдээлэлтэй болох. Ахмадууд цахим орчинд ташаа мэдээлэлд автах, эрсдэлд орох нь их.
<p>Хөдөө орон нутгийн иргэд</p>	<ul style="list-style-type: none"> ● Мэдээллийн хүртээмжтэй холбоотой бэрхшээл тайланд тодорхойлоогүй.
<p>Хөгжлийн бэрхшээлтэй иргэд</p>	<ul style="list-style-type: none"> ● Мэдээллийн стандарт. Нэгдсэн стандарт, арга зүй, заавар байхгүй. Улмаар мэдээллийн хүртээмж хангалтгүй. Бичиг баримт, нэхэмжлэлийн маягт уншиж бөглөхөд туслах технологи, аудио/брайл хувилбар байхгүй. Шүүхийн шийдвэрийг уншиж танилцах боломжгүй, хялбаршуулсан, аудио хувилбар гардаггүй. ● Мэдээлэл олж авах ба ойлгох бэрхшээл. Ихэнх оролцогчид шүүхэд хэрхэн хандах, ямар бичиг баримт бүрдүүлэх талаар албан ёсны эх сурвалжаас бус, харин найз нөхөд, танил, багш зэргээс мэдээлэл авсан гэж дурдсан. Шүүхийн цахим хуудсууд болон мэдээллийн самбар дахь тайлбар, баримт бичгийн хэллэгүүд хэт мэргэжлийн, хууль зүйн нэр томьёо давамгайлсан байдлаар бичигддэг нь ойлгоход төвөгтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд төдийгүй олон нийтэд ч хүндрэл учруулдаг.
<p>Хүүхэд</p>	<ul style="list-style-type: none"> ● Мэдээлэл. Хэдийгээр шүүх бүр мэдээллийн самбартаа мэдээлэл тавьсан байдаг боловч тэдгээр нь хэт ерөнхий, хуулийн хэллэг ашигласан байдаг тул ойлгодоггүй.
<p>Залуучууд</p>	<ul style="list-style-type: none"> ● Хууль зүйн зөвлөгөө, туслалцааны хүртээмж муу. Хууль зүйн зөвлөгөө, туслалцааны хүртээмж ялангуяа орон нутагт муу. Мөнгө төлөөд өмгөөлөгч авах гэхээр орон нутагт ажиллах хүчний

	<p>дутагдлаас шалтгаалан чадварлаг өмгөөлөгч олддоггүй, олдсон ч хэтэрхий үнэтэй.</p> <ul style="list-style-type: none"> ● Асуудал тулгарсан үед ямар байгууллагад хандах талаар мэдлэг хомс, мэдээлэл байхгүй. Хохирсон тохиолдолд хаана хандах, ямар байдлаар гомдол, мэдээлэл өгөх зэрэг нь тодорхойгүй. ● Бие даан судлах гэхээр хэт мэргэжлийн. Шүүхийн бүтэц, үйл ажиллагаа болон эрх зүйн журам, заалтуудын талаар мэдээлэл хангалтгүй. Бие даан судлах гэхээр хангалттай ойлгодоггүй. Хууль зүйн аливаа зүйлсийн хялбаршуулсан, энгийншүүлсэн мэдээлэл хомс. ● Баталгаагүй мэдээлэлтэй болох. Залуучууд өөрсдөө шүүхэд хандсан тохиолдолд цөөн бөгөөд шүүхийн талаар цахим орчноос баталгаагүй мэдээлэл авснаар буруу ойлголттой болдог.
Эмэгтэйчүүд	<ul style="list-style-type: none"> ● Орон нутагт мэдээлэл авах хэцүү. Хөдөө сүлжээгүй, интернэтгүй газар мэдээлэл авах боломж хомс.
Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон иргэд	<ul style="list-style-type: none"> ● Мэдээлэл бүрхэг. Өөрөө л асуухгүй бол шүүхээс аливаа мэдээллийг хүргэдэггүй. Бүх юм болоод өнгөрсний дараа мэдэх явдал олон.

Хүснэгт 8. Технологи, цахимжилт дагасан бэрхшээл: Шүүх хурал цахимаар явагдах, шүүхийн процессын талаарх мэдээллийг шүүгчийн туслахаас viber-аар авах, хууль, эрх зүйн баримт бичгүүдэд цахимаар санал авах гм. “цахим” үйл ажиллагаанууд нь нийгмийн тодорхой бүлгүүдийн хувьд хэр байдаг вэ? (зөвхөн энэ жишээгээр хязгаарлагдажгүй)

Ахмад настан	<ul style="list-style-type: none"> ● Цахимаар л мэдээлэл хүргэх болсон нь хүртээмж муу. Ахмадуудын цахим хэрэглээний чадвар сул, ухаалаг утас, компьютер ашиглахад хүндрэлтэй. Цахим үйлчилгээ зөвхөн залуу үе, дижитал хэрэглэгчдэд ээлтэй, ахмадууд орхигддог. Мөн хөдөө орон нутгийн ахмадууд интернэт сүлжээ сул, төхөөрөмжийн хүчин чадал багатай байдаг. ● Баримт бичгийн давхардал. Цахим үйлчилгээ нэмэгдэхийн хэрээр цаасан бичиг баримт улам ихэсдэг, давхардал бий болдог. ● Баталгаагүй мэдээлэлтэй болох. Ахмадууд цахим орчинд ташаа мэдээлэлд автах, эрсдэлд орох нь их.
Хөдөө орон нутгийн иргэд	<ul style="list-style-type: none"> ● Шүүх хуралд цахимаар орох хүндрэл. “Шүүх хуралдаанд оролцогчийг зайнаас буюу цахимаар оролцуулах ажлыг зохион байгуулах журам” нь хууль зүйн оролцоог дэмжих зорилготой боловч орон нутгийн иргэдийн хувьд хэрэгжилт нь хязгаарлагдмал байна. Алслагдсан сумдын иргэдийн дийлэнх нь ухаалаг төхөөрөмжгүй, интернэтийн сүлжээ сул, Zoom зэрэг платформ ашиглах чадваргүй, оролцох орон зайгүй, дүү дүрсний чанар хангалтгүй
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	<ul style="list-style-type: none"> ● Технологи, цахимжилттай холбоотой бэрхшээлийг тайланд тодорхойлоогүй.
Хүүхэд	<ul style="list-style-type: none"> ● Цахим шийдлүүдийг зөв ашиглахгүй бол хүний хувийн мэдээллийн нууцлалыг хангаж чаддаггүй. Шүүх хурлын товыг цахимд байршуулах болон шүүхийн хүлээлгийн танхимд ил байрлуулдаг нь хэдийгээр ил тод байдлыг хангаж байгаа боловч

	<p>нөгөө талдаа шүүгдэгч, холбогдогчийн нэр ил гарч байгаа тул хүний хувийн мэдээллийн нууцлалыг хангаж чадахгүй байна.</p> <ul style="list-style-type: none"> ● Шийтгэх тогтоолыг цахимд (shuukh.mn) байршуулахдаа хүний хувийн мэдээллийн нууцлалыг хангахгүй байна. Цахимд байршуулсан мэдээлэлд заримдаа шүүгдэгч, хохирогч зэргийн нэр, төрсөн он сар өдөр, гэрийн хаяг зэрэг хувийн мэдээлэл байршуулснаар тэдгээрийг олон нийтийн сүлжээнд цацах, подкаст бэлтгэх зэргээр түгээснээр хохирогч/даван түүлагч, тэдний гэр бүлийн сэтгэцийн гэмтлийг сэдрээх сөрөг үр дагаварт хүргэж байна.
Залуучууд	<ul style="list-style-type: none"> ● Технологи, цахимжилт дагасан бэрхшээл тодорхойлоогүй.
Эмэгтэйчүүд	<ul style="list-style-type: none"> ● Цахим хурал. Цахимаар шүүх хуралд орох үед гацдаг, дуу, дүрс алга болдог. Энэ нь шийдвэр бодитой гарах эсэхэд нөлөөлж байна гэж боддог. ● Цахимаар явуулсан мэйл, чат зэргийг нотлох баримтаар тооцох эсэх нь үзэмжийн асуудал байдаг.
Гэмт хэрэг, зөрчлийн хохирогч болсон иргэд	<ul style="list-style-type: none"> ● Цахим хурал. Цахимаар шүүх хуралд орох үед гацдаг, дуу, дүрс алга болдог.


Хүснэгт 9. Судалгааг гүйцэтгэсэн Төрийн бүс байгууллагуудын товч танилцуулга

Ажлын хэсэгт ажилласан 8 төрийн бүс байгууллагын мэдээллийг дор оруулав.

Төрийн бүс байгууллага	Гүйцэтгэсэн судалгаа	Үйл ажиллагааны товч танилцуулга
1.Оюуны-Инноваци НҮТББ	Бүлгийн нэгтгэл, суурь судалгаа	Тус ТББ нь 2013 онд байгуулагдсан. Эрх зүйн шүүмж судлалыг хөгжүүлэх; хууль зүйн судалгааг дэмжих, хөгжүүлэх, судалгааны бүтээлийг түгээх; эрх зүйн бодлогын академик болон хавсарсан судалгаа хийх; Хууль тогтоомжийн төсөл боловсруулах; төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, үнэлгээ мониторинг хийх; сургалт зохион байгуулах; байгаль орчин, нийтийн эрүүл мэнд, нийтийн өмч, хүүхэд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг болно.
2.Монголын ахмадын холбоо ТББ	Ахмад настнуудын шударга ёсны хүртээмжийн судалгаа	Монголын ахмадын холбоо нь 1931 онд байгуулагдсан бөгөөд ахмад настны олонхын нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах, тэдний амьжиргаа, эрүүл мэнд, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн оролцоог дэмжих, ая тухтай амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд зорин Ахмад настны тухай хуулийг хэрэгжүүлэх, ахмад настан, иргэд олон нийтэд төрөөс ахмадын талаар баримталж буй төрийн бодлого шийдвэрийг сурталчлан таниулах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд бодитой дэмжлэг үзүүлэхэд чиглэгдсэн төрийн тодорхой чиг үүргийг гэрээлэн хариуцах зарчмаар Монгол Улсын Засгийн газар, Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, түүний харьяа төв, орон нутаг, төр, захиргааны байгууллагуудтай хамтран ажилладаг.
3.Баруун бүсийн хөгжлийн төв ТББ	Орон нутгийн иргэдийн шударга ёсны хүртээмжийн судалгаа	Баруун бүсийн хөгжлийн төв нь 2024 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улсын баруун бүс нутгийн хөгжлийг хурдасгах, тэгш хүртээмжтэй эдийн засгийн өсөлтийг дэмжих, нийгэм, байгаль орчны тогтвортой байдлыг хангахад дэмжлэг үзүүлэх зорилгоор судалгаа, шинжилгээнд суурилсан бодлогын дүн шинжилгээ, санал, зөвлөмж боловсруулах, хөгжлийн оновчтой шийдлүүдийг дэвшүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бодлогын судалгааны байгууллага юм.
4.Тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо ТББ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн шударга ёсны хүртээмжийн судалгаа	Монголын Тэргэнцэртэй Иргэдийн Үндэсний Холбоо нь 2005 онд байгуулагдсан бөгөөд тэргэнцэртэй болон тулгуур эрхтний бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний эрхийн төлөө тэгш оролцоот, хүртээмжтэй нийгмийг бий болгох, эрх ашгийг нь хамгаалахаар үйл ажиллагаа явуулдаг.
5.Хөөрхөн зүрх ТББ	Хүүхдүүдийн шударга ёсны хүртээмжийн судалгаа	Хөөрхөн Зүрх ТББ нь 2012 онд байгуулагдсан бөгөөд Монгол Улсад хүүхдийн эсрэг бэлгийн хүчирхийллийг таслан зогсоох, жендэрийн эрх тэгш байдлыг дэмжих

	судалгаа	үйл ажиллагааг хэрэгжүүлж буй улс төр, шашны нөлөөнөөс ангид, хүүхэд хамгааллын магадлан итгэмжлэгдсэн төрийн бус байгууллага юм.
6.Бодлогод залуусын хяналт ТББ	Залуучуудын шударга ёсны хүртээмжтэй байдлын судалгаа	Тус байгууллага нь 2014 онд байгуулагдсан бөгөөд бодлого боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад залуучуудын утга учиртай оролцоо, дуу үгүүлэгдэж буй өөрчлөх зорилгоор байгуулагдсан бөгөөд өдгөө тус байгууллагын дэргэд 16-22 насны гишүүнчлэлтэй “Залуусын давлагаа клуб” 2018 оноос ажиллаж байгаа бөгөөд клуб нь дуу хоолой нь хүрэхгүй байгаа залуучуудын бүлгийг чадавхжуулж, ардчиллын үнэт зүйлсийг таниулах, гэр хороололд амьдарч буй залуучуудын асуудлыг бодлогын түвшинд шийдвэрлүүлэх зорилготой үйл ажиллагааг хэрэгжүүлдэг.
7.Монфемнет Үндэсний Сүлжээ	Эмэгтэйчүүд болон гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчдын шударга ёсны хүртээмжийн судалгаа	Монфемнет Үндэсний Сүлжээ нь 2000 онд байгуулагдсан бөгөөд эмэгтэйчүүдийн хүний эрх, жендэрийн тэгш байдал, нийгмийн шударга ёсыг хангахын төлөө ажилладаг 19 байгууллагын гишүүнчлэлтэй, нийгэмд үйлчилдэг ашгийн бус, нам бус, төрийн бус байгууллага юм.
8.Тогтолцоо дүн шинжилгээ судалгааны хүрээлэн НҮТББ	Шударга ёсны хүртээмжит байдлын олон улсын түршлага болон Бүлгийн судалгааны нэгтгэсэн тайлан	Тус байгууллага нь 2023 онд байгуулагдсан бөгөөд эрх зүйт ёсыг төлөвшүүлэх зорилгоор эрх зүйн болон бодлогын судалгаа гүйцэтгэх, хэлэлцүүлэг зохион байгуулах, хууль, эрх зүйн мэдээ мэдээллийг олон нийтэд ойлгомжтой байдлаар хүргэх төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Хүснэгт 10. Судалгаанд хамрагдсан нийт оролцогчдыг нийгмийн бүлгийн үзүүлэлт



Хүснэгт 11. Судалгаанд оролцогчдын нарийвчилсан мэдээлэл

Нийгмийн бүлэг	Байршил	Насны бүлэг	Хүйс	Бусад	Асуулга авсан хэлбэр
Ахмад настан	Улаанбаатар хот, 21 аймаг	57-75 нас	Эмэгтэй, эрэгтэй	Олон төрлийн мэргэжилтэй иргэд хамрагдсан.	Тоон болон чанарын судалгааг асуулга болон ярилцлагын хэлбэрээр гүйцэтгэсэн.
Хөдөө орон нутгийн иргэд	Баян-Өлгий, Говь-Алтай, Завхан, Ховд, Увс аймгууд	Бүх насны бүлэг	Эмэгтэй, эрэгтэй	Угсаатан, ястны цөөнх болон малчин иргэд хамрагдсан.	Цахим судалгаа, анкет болон ярилцлагын хэлбэрээр гүйцэтгэсэн.
Хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Улаанбаатар хот, Өвөрхангай, Хэнтийн аймгууд	20-60 нас	Эмэгтэй, эрэгтэй	Харааны, тулгуур эрхтний, сонсголын болон оюуны хөгжлийн бэрхшээлтэй иргэд хамрагдсан.	Баримт бичгийн судалгаа болон ганцаарчилсан ярилцлагын хэлбэрээр гүйцэтгэсэн.
Хүүхэд	Улаанбаатар хот, Дорноговь,	18 хүртэл нас ⁵	Эмэгтэй, эрэгтэй	Шүүхийн үйл ажиллагаанд оролцогч хүүхдүүд, тэдгээрийн	Хагас нээлттэй ганцаарчилсан ярилцлагын арга

⁵ Судалгаанд оролцогчдын хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч, хохирогч хүүхдийн асран хамгаалагч нарын хувьд 30-63 насны хүмүүс байсан.

	Завхан, Баян-Өлгий аймгууд			асран хамгаалагч, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид хамрагдсан.	болон фокус бүлгийн ярилцлагын хэлбэрээр гүйцэтгэсэн.
Залуучууд	Улаанбаатар хот	15–34 нас	Эмэгтэй, эрэгтэй	15-34 насны залуучуудын бүлэг хамрагдсан.	Тоон судалгааны хүрээнд цахим санал асуулга авсан. Чанарын судалгааны хүрээнд ганцаарчилсан ярилцлагын аргыг ашигласан.
Эмэгтэйчүүд	Улаанбаатар хот	Бүх насны бүлэг	Эмэгтэй	Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах, эмэгтэйчүүд оролцсон хэрэг маргаанд оролцдог өмгөөлөгч, хуульч, мэргэжилтнүүд хамрагдсан.	Фокус бүлгийн ярилцлага
Гэмт хэрэг, зөрчлийн хохилогч болсон иргэд	Улаанбаатар хот	Бүх насны бүлэг	Эмэгтэй	Эрүүгийн хэрэгт хохилогчоор, гэрлэлт цуцлах, хүүхдийн тэтгэмж тогтоох, тэжээн тэтгэлэг гаргуулах, эвлэрүүлэн зуучлах, эд хөрөнгийн маргаан, зөрчлийн хэрэг зэрэгт оролцож байсан эмэгтэйчүүд хамрагдсан.	Фокус бүлгийн ярилцлага

---ooOoo---